**ИХЭРМӨРӨН-АУДИТ ХХК**

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

# Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ХӨА-2024/197/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Мөрөн сум<br>2024 он | Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,<br>тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар<br>Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn<br>Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр<br>Утас: 99089114 Цахим хаяг:tegshdelgerb@audit.gov.mn<br>Аудитор: Г.Ичинхорлоо<br>Утас:88688168 Цахим хаяг: ichinkhorloog@audit.gov.mn<br>Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн захирал Б.Мядагмаа<br>Утас:99389208 Цахим хаяг: b_myadagmaaa@yahoo.com<br>Аудитор Ц.Мөнхтуяа<br>Утас: 99382220 Цахим хаяг: munkhtuya2220@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ


ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn


2024.02.26 № 01/170

танай ______________ -ны № ______________ -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЦЭЦЭРЛЭГ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Х.ТӨРМӨНХ ТАНАА

### Хараат бус аудиторын дүгнэлт

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цэцэрлэг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цэцэрлэг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх үндсэн хөрөнгийн дүн өмнөх оноос 91,874.2 мянган төгрөгөөр буурсан байна.

**Аудитын гол асуудал**

Аудитаар батлагдсан төсвийг хөтөлбөр, арга хэмжээний зориулалтаар зарцуулаагүй 4,839.2 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өглөө.

**Бусад асуудлын хэсэг**

Тус сургуулийн захирал нь 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг Цэцэрлэг сумын Засаг дарга, Хөвсгөл аймгийн Боловсрол шинжлэх ухааны газрын даргаар батлуулж, түүнийг 91.0 хувьтай биелүүлж ажилласан байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

6724040206

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **440,124,321.50** | **554,808,903.14** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **106,828,989.34** | **279,727,540.71** |
| **31200** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | **106,828,989.34** | **279,727,540.71** |
| **31210** | **Төгрөг** | **106,828,989.34** | **279,727,540.71** |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 106,828,989.34 | 279,727,540.71 |
| **33** | **АВЛАГА** | **989,100.00** | |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 65,100.00 | |
| **33500** | **Бусад авлага** | **924,000.00** | |
| 33510 | Байгууллагаас авах авлага | 924,000.00 | |
| **34** | **УРЬДЧИЛГАА** | | **2,624,523.35** |
| 34600 | Урьдчилж гарсан зардал | | 2,624,523.35 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **332,306,232.16** | **272,456,839.08** |
| **35100** | **Түүхий эд материал** | **84,428,808.80** | **71,066,630.09** |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 82,105,706.80 | 69,171,630.09 |
| 35130 | Эм боох материал | 2,323,102.00 | 1,895,000.00 |
| **35400** | **Хангамжийн материал** | **247,877,423.36** | **201,390,208.99** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 4,712,698.00 | 2,602,702.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 2,340,982.42 | 2,015,352.42 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 5,003,500.00 | 3,312,000.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 62,688,253.00 | 20,177,500.00 |
| 35460 | Хүнсний материал | 24,145,125.00 | 23,145,685.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 148,986,864.94 | 150,136,969.57 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,336,818,381.91** | **1,244,944,233.68** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **1,336,818,381.91** | **1,244,944,233.68** |
| **39200** | **Биет хөрөнгө** | **1,239,105,381.67** | **1,148,753,233.36** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,196,320,753.00 | 1,076,937,593.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -406,754,112.76 | -346,142,328.52 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 355,776,449.43 | 407,162,369.43 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -117,161,624.91 | -224,008,603.76 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 205,289,138.76 | 210,199,138.76 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -65,270,737.57 | -90,859,702.43 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 52,705,700.00 | 101,010,653.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -9,149,285.28 | -17,492,673.72 |
| 39217 | Ном | 27,349,101.00 | 31,946,787.60 |
| **39300** | **Биет бус хөрөнгө** | **97,713,000.24** | **96,191,000.32** |
| 39301 | Програм хангамж | 7,535,000.00 | 7,535,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -3,671,999.76 | -5,193,999.68 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 93,850,000.00 | 93,850,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,776,942,703.41** | **1,799,753,136.82** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,776,942,703.41** | **1,799,753,136.82** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **1,776,942,703.41** | **1,799,753,136.82** |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 1,124,890,766.00 | 1,124,890,766.00 |
| 511002 | Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө | 1,124,890,766.00 | 1,124,890,766.00 |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | **-150,703,519.33** | **-70,358,533.78** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -150,703,519.33 | -93,168,967.19 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | | 22,810,433.41 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 802,755,456.74 | 745,220,904.60 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,776,942,703.41** | **1,799,753,136.82** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,972,619,324.41** | **2,244,425,765.87** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **161,644,024.41** | **21,312,165.87** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **161,644,024.41** | **21,312,165.87** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **8,561,300.00** | |
| 1E+06 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 3,785,100.00 | |
| 1E+06 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 4,776,200.00 | |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 72,192,624.91 | 13,897,006.60 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 80,890,099.50 | 7,415,159.27 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,810,975,300.00** | **2,223,113,600.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **1,528,134,500.00** | **1,985,317,800.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,528,134,500.00 | 1,985,317,800.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **10,500,000.00** | |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 10,500,000.00 | |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **272,340,800.00** | **237,795,800.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 272,340,800.00 | 237,795,800.00 |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,846,969,582.52** | **2,221,615,332.46** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,846,969,582.52** | **2,221,615,332.46** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,766,805,447.70** | **2,157,239,897.46** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,077,657,366.31** | **1,337,019,731.86** |
| 210101 | Үндсэн цалин | 796,596,556.35 | 952,563,846.86 |
| 210102 | Нэмэгдэл | 216,481,194.96 | 319,862,218.00 |
| 210104 | Урамшуулал | 64,579,615.00 | 64,593,667.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **136,078,608.35** | **167,552,510.77** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 93,072,289.53 | 114,207,014.15 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 10,957,403.88 | 13,416,060.26 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 8,368,411.89 | 10,649,225.26 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,152,772.36 | 2,657,070.50 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 21,527,730.69 | 26,623,140.60 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **195,013,661.18** | **205,643,300.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,290,065.18 | 10,800,000.00 |
| 210302 | Түлш, халаалт | 180,425,850.00 | 184,043,300.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 8,297,746.00 | 10,800,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **19,315,130.00** | **52,400,498.35** |
| 210401 | Бичиг хэрэг | 281,360.00 | 2,264,646.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 11,622,870.00 | 10,785,550.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 220,600.00 | 68,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 6,280,300.00 | 11,113,980.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 910,000.00 | 28,168,322.35 |
| **2105** | **Нормативт зардал** | **104,063,565.00** | **129,895,762.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,692,020.00 | 715,102.00 |
| 210502 | Хоол, хүнс | 102,371,545.00 | 129,180,660.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **21,885,100.00** | **28,049,800.00** |
| 210604 | Урсгал засвар | 21,885,100.00 | 28,049,800.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **12,932,100.00** | **6,662,376.65** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 4,793,100.00 | |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 8,139,000.00 | 6,662,376.65 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **199,859,916.86** | **230,015,917.83** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 14,703,400.00 | 14,579,960.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 8,080,800.00 | 14,363,250.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 177,075,716.86 | 201,072,707.83 |

| | | | |
|---|---|---|---|
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **80,164,134.82** | **64,375,435.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **79,548,895.00** | **64,375,435.00** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 66,029,395.00 | 64,375,435.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 13,519,500.00 | |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **615,239.82** | |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 615,239.82 | |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **102,619,684.09** | **22,810,433.41** |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | **102,619,684.09** | **22,810,433.41** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,819,536,600.00** | **2,223,113,600.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **8,561,300.00** | **4,978,700.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **8,561,300.00** | **4,978,700.00** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **8,561,300.00** | **4,978,700.00** |
| 1E+06 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 3,785,100.00 | 4,540,700.00 |
| 1E+06 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 4,776,200.00 | 438,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,810,975,300.00** | **2,218,134,900.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **1,528,134,500.00** | **1,980,339,100.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,528,134,500.00 | 1,980,339,100.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **10,500,000.00** | |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 10,500,000.00 | |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **272,340,800.00** | **237,795,800.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 272,340,800.00 | 237,795,800.00 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,644,567,320.66** | **2,003,218,448.63** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,644,567,320.66** | **2,003,218,448.63** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,562,182,185.84** | **1,941,600,413.63** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,077,657,366.31** | **1,337,019,731.86** |
| 210101 | Үндсэн цалин | 796,596,556.35 | 945,497,717.57 |
| 210102 | Нэмэгдэл | 216,481,194.96 | 328,676,433.42 |
| 210104 | Урамшуулал | 64,579,615.00 | 62,845,580.87 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **136,143,708.35** | **167,487,410.77** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 92,939,798.53 | 114,246,411.80 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 10,890,203.88 | 13,311,559.90 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 8,651,682.89 | 10,649,248.31 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,151,092.05 | 2,657,069.95 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 21,510,931.00 | 26,623,120.81 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **196,225,611.18** | **203,951,800.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,290,065.18 | 10,800,000.00 |
| 210302 | Түлш, халаалт | 181,637,800.00 | 182,351,800.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 8,297,746.00 | 10,800,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **500,000.00** | |
| 210402 | Тээвэр, шатахуун | 500,000.00 | |
| **2105** | **Нормативт зардал** | **69,859,400.00** | **130,938,620.00** |
| 210502 | Хоол, хүнс | 69,859,400.00 | 130,938,620.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **12,794,900.00** | **33,844,000.00** |
| 210604 | Урсгал засвар | 12,794,900.00 | 33,844,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **12,932,100.00** | **15,356,600.00** |

| | | | |
|---|---|---|---|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,785,100.00 | 4,540,700.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 9,147,000.00 | 10,815,900.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **56,069,100.00** | **53,002,251.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 36,029,600.00 | 38,339,001.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 20,039,500.00 | 14,663,250.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **82,385,134.82** | **61,618,035.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **81,769,895.00** | **61,618,035.00** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 68,250,395.00 | 61,618,035.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 13,519,500.00 | |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **615,239.82** | |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 615,239.82 | |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **174,969,279.34** | **219,895,151.37** |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **68,140,290.00** | **46,996,600.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **68,140,290.00** | **46,996,600.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **68,140,290.00** | **46,996,600.00** |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 68,140,290.00 | 46,996,600.00 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **-68,140,290.00** | **-46,996,600.00** |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | **106,828,989.34** | **172,898,551.37** |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 106,828,989.34 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 106,828,989.34 | 279,727,540.71 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **1** | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,124,890,766.00** | **802,755,456.74** | **-368,923,332.80** | **1,558,722,889.94** |
| 9 | Тайлант үеийн үр дүн | | | 218,219,813.47 | 218,219,813.47 |
| 10 | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 1,124,890,766.00 | 802,755,456.74 | -150,703,519.33 | 1,776,942,703.41 |
| 11 | 2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 1,124,890,766.00 | 802,755,456.74 | -150,703,519.33 | 1,776,942,703.41 |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | 57,534,552.14 | 57,534,552.14 |
| 13 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 1,124,890,766.00 | 802,755,456.74 | -93,168,967.19 | 1,834,477,255.55 |
| 14 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | | -57,534,552.14 | | -57,534,552.14 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | | | 22,810,433.41 | 22,810,433.41 |
| **20** | **2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл** | **1,124,890,766.00** | **745,220,904.60** | **-70,358,533.78** | **1,799,753,136.82** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хувь | Зөрүү |
|---|---|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **2,092,112,700.00** | **1,812,419,248.63** | 86.63 | **279,693,451.37** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,092,112,700.00** | **1,812,419,248.63** | 86.63 | **279,693,451.37** |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,010,942,300.00** | **1,750,801,213.63** | 87.06 | **260,141,086.37** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,554,919,700.00** | **1,337,019,731.86** | 85.99 | **217,899,968.14** |
| 210101 | Үндсэн цалин | 1,071,411,800.00 | 945,497,717.57 | 88.25 | 125,914,082.43 |
| 210102 | Нэмэгдэл | 407,651,700.00 | 328,676,433.42 | 80.63 | 78,975,266.58 |
| 210104 | Урамшуулал | 75,856,200.00 | 62,845,580.87 | 82.85 | 13,010,619.13 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **194,365,400.00** | **167,487,410.77** | 86.17 | **26,877,989.23** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 132,168,400.00 | 114,246,411.80 | 86.44 | 17,921,988.20 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 15,549,300.00 | 13,311,559.90 | 85.61 | 2,237,740.10 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 12,439,400.00 | 10,649,248.31 | 85.61 | 1,790,151.69 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,109,900.00 | 2,657,069.95 | 85.44 | 452,830.05 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 31,098,400.00 | 26,623,120.81 | 85.61 | 4,475,279.19 |
| **2105** | **Нормативт зардал** | **144,091,900.00** | **130,938,620.00** | 90.87 | **13,153,280.00** |
| 210502 | Хоол, хүнс | 144,091,900.00 | 130,938,620.00 | 90.87 | 13,153,280.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **15,356,600.00** | **15,356,600.00** | 100.00 | |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 4,540,700.00 | 4,540,700.00 | 100.00 | |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 10,815,900.00 | 10,815,900.00 | 100.00 | **0.00** |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **102,208,700.00** | **99,998,851.00** | 97.84 | **2,209,849.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 85,984,800.00 | 83,774,951.00 | 97.43 | 2,209,849.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 16,223,900.00 | 16,223,900.00 | 100.00 | |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **81,170,400.00** | **61,618,035.00** | 75.91 | **19,552,365.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **81,170,400.00** | **61,618,035.00** | 75.91 | **19,552,365.00** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 81,170,400.00 | 61,618,035.00 | 75.91 | 19,552,365.00 |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **2,092,112,700.00** | **1,985,317,800.00** | 94.90 | **106,794,900.00** |
| **31** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **1,980,339,100.00** | **1,980,339,100.00** | 100.00 | **0.00** |
| 310001 | Улсын төсвөөс санхүүжих | 1,980,339,100.00 | 1,980,339,100.00 | 100.00 | **0.00** |
| **35** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **111,773,600.00** | **4,978,700.00** | 4.45 | **106,794,900.00** |
| 350001 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 4,540,700.00 | 4,540,700.00 | 100.00 | **0.00** |
| 350002 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 438,000.00 | 438,000.00 | 100.00 | **0.00** |
| 350003 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 106,794,900.00 | | 0.00 | 106,794,900.00 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 106,828,989.34 | | -106,828,989.34 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 279,727,540.71 | | -279,727,540.71 |

## Орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

төгрөгөөр

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хувь | Зөрүү |
|---|---|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **237,795,800.00** | **237,795,800.00** | 100 | 0.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **237,795,800.00** | **237,795,800.00** | 100 | 0.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **237,795,800.00** | **237,795,800.00** | 100 | 0.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **203,951,800.00** | **203,951,800.00** | 100 | 0.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 10,800,000.00 | 10,800,000.00 | 100 | 0.00 |
| 210302 | Түлш, халаалт | 182,351,800.00 | 182,351,800.00 | 100 | 0.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 10,800,000.00 | 10,800,000.00 | 100 | 0.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **33,844,000.00** | **33,844,000.00** | 100 | 0.00 |
| 210604 | Урсгал засвар | 33,844,000.00 | 33,844,000.00 | 100 | 0.00 |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **237,795,800.00** | **237,795,800.00** | 100 | 0.00 |
| **32** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **232,795,800.00** | **237,795,800.00** | 102.15 | **-5,000,000.00** |
| 320001 | Орон нутгийн төсвөөс | 232,795,800.00 | 237,795,800.00 | 102.15 | -5,000,000.00 |
| **35** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **5,000,000.00** | **0** | 0 | **5,000,000.00** |

## 3.АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 4,839.2 мянган төгрөгийн зөрчил[1] илэрснээс, 4,839.2 мянган төгрөгийн 2 зөвлөмж хүргүүллээ.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 4,839.2 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдлын түвшнээс 35,293.1 мянган төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

### 3.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

*Илрүүлэлт:*

Тус сургуулийн үндсэн хөрөнгөнд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 79 нэр төрлийн 145,946.2 мянган төгрөгийн 326 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байгаа нь УСНББОУС-17 “Үндсэн хөрөнгө”-ийн параграф 67, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3“холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;” заалт болон ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолын 7 дугаар бүлгийн 7.1 заалттай тус тус нийцээгүй, “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж*:

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг ОНӨГ-т хүргүүлэн шийдвэрлүүлж, үр дүнг нягтлан бодох бүртгэлд тусгах

2. Төсвийн гүйцэтгэлтэй холбоотой асуудал

*Илрүүлэлт:*

Цалингийн зардлаас ЭДЭ шалом ХХК-ний багш Ш.Эрдэнэбаярт цахилгаан хөгжмийн сургалт явуулсан ажлын хөлс 2,000.0 мянган төгрөг, багшийн хөгжлийн зардлаас шатахууны зардалд 2,839.2 төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах;” заалт, БШУС-ын 2019

оны А/170 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Хичээл сургалтын үйл ажиллагааны зардлыг төлөвлөх, хуваарилах заавар”, Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолоор батлагдсан “Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх аргачлал”–ын хавсралтад заасан зориулалт, арга хэмжээтэй нийцэхгүй “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

Төсвийг батлагдсан зориулалт, арга хэмжээний дагуу, холбогдох хууль, журам, зааварт нийцүүлэн зарцуулж байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайлан хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үндсэн хөрөнгө нягтлан бодох бүртгэлд бүртгэлтэй байна. | 1 | 0 | | | | | 1 | - |
| Цалингийн зардлаас ЭДЭ шалом ХХК-ний багш Ш.Эрдэнэбаярт цахилгаан хөгжмийн сургалт явуулсан ажлын хөлс 2,000.0 мянган төгрөг, багшийн хөгжлийн зардлаас шатахууны зардалд 2,839.2 төгрөгийг зарцуулсан | 1 | 4,839.2 | | | | | 1 | 4,839.2 |
| **Дүн** | **2** | **4,839.2** | | | | | **2** | **4,839.2** |

## 5.Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | Аудитад хамрагдах | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТШЗ | 1 | 1 | | | 1 | | | |
| | **НИЙТ** | **1** | **1** | | | **1** | | | |